



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020-03-02 № 0572447
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД
ТАНАА

Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн Иргэний нисэхийн салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Өлзийсайханы Мөнгөнжигүүрийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин нэр дэвшигч нь нэр дэвшиж буй ажлын байрны албан тушаалын тусгай шалгалт өгөөгүй нь Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, 33.3-т заасны дагуу төрийн албаны тусгай шалгалт буюу албан тушаалын шалгалт өгч зохих журмын дагуу нэр дэвшүүлснээр төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох эрх зүйн зохицуулалтыг зөрчихөөр байх тул түүнийг тухайн албан тушаалд шууд жинхлэн томилох эсэхийг дээрх хуульд нийцүүлэн шийдвэрлэхээр байна.

Түүнчлэн нэр дэвшигчийн эрхлэх асуудал, харьяалах нутаг дэвсгэрт түүний хамаарал бүхий этгээд болох эхнэр Д.Оюундэлгэр агаарын хөлгөөр зорчигч болон ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэх "Изинис-Эйр вэйз" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байх тул тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарч ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

0003593